



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Их Монгол Засахуй Ухаан намыг шинээр  
бүртгүүлэх хүсэлтийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Их Монгол Засахуй Ухаан нам үүсгэн байгуулагдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг шүүгч П.Соёл-Эрдэнийн танилцуулснаар хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэн Б.Ганзоригоос: "...Б.Ганзориг миний бие Улс төрийн намын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасныг үндэслэн сайн дурын үндсэн дээр нам байгуулах, Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхээ эдэлж эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үүднээс "Их Монгол Засахуй Ухаан намыг үүсгэн байгуулахаар энэхүү өргөдлийг гаргаж байгаа билээ. Манай намын хаяг нь Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө, "Грэй оффис"-ын 303 тоот хаягт байрлах бөгөөд нийт 801-1000 орчин гишүүд дэмжигчид намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, дүрмийг хүлээн зөвшөөрч эвлэлдэн нэгдээд байна. Иймд журмын нөхдийн хамт санаачлан үүсгэн байгуулж буй "Их Монгол Засахуй Ухаан" намыг байгуулах энэхүү өргөдлийг хүлээн авч намын албан ёсны бүртгэлд бүртгэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж өгнө үү" гэх хүсэлт гаргаж,

2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн хүсэлтдээ "Хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт, Их Монгол Засахуй Ухаан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн мэдээлэл, нам үүсгэн байгуулах хурлын 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 22/01 дүгээр тогтоол, 01 дугаартай Намын үүсгэн байгуулах их хуралд хүрэлцэн ирсэн гишүүд, дэмжигч, төлөөлөгчдийн бүртгэл, Их Монгол Засахуй Ухаан намын үүсгэн байгуулах хурлын тов мэдэгдсэн баримт, Их Монгол Засахуй Ухаан намын бэлгэдэл далбааны тайлбар, намын дүрэм, намын мөрийн хөтөлбөр, "Өдрийн сонин"-ы он, сар, дугаар байхгүй хуулбар хувь, Хан-Уул дүүргийн 19 дүгээр хорооны Засаг даргын тодорхойлолт, намын санхүүгийн асуудал эрхэлсэн эрх бүхий удирдах ажилтны бүртгэл, дипломын хуулбар, намын хөрөнгийн мэдээлэл, улсын тэмдэгтийн хураамж, Их Монгол Засахуй Ухаан намын дэмжигч 818 гишүүдийн бүртгэл" зэргийг хавсарган ирүүлжээ.

2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн материалдаа “2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн түрээсийн гэрээ, Нам үүсгэн байгуулах хурлын 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 22/01 дүгээр тогтоол, намыг үүсгэн байгуулах хурлын 01 дугаартай тэмдэглэл, намын үүсгэн байгуулах их хуралд хүрэлцэн ирсэн үүсгэн байгуулагч гишүүдийн ирцийн бүртгэл, намын үүсгэн байгуулагч гишүүдийн мэдээлэл, Хан-Уул дүүргийн 19 дүгээр хорооны Засаг даргын тодорхойлолтын хуулбар, 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өдрийн сонин”-ы №228 дугаар, нотариатаар баталгаажуулсан хуулбар хувь, Их Монгол Засахуй Ухаан намын дэмжигч 818 гишүүдийн бүртгэл” зэргийг ирүүлсэн байна.

#### ҮНДЭСЛЭХ нь:

Их Монгол Засахуй Ухаан нам үүсгэн байгуулагдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай иргэн Б.Ганзоригийн хүсэлт нь хуульд заасан шаардлагыг хангаагүй байх тул улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Улсын дээд шүүх намыг дараах үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана”, 10.1.3-т “гишүүдийн тоо нь энэ хуулийн 9.3.7-д заасан тоонд хүрээгүй ...” гэж, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7-д “намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл” гэж тус тус заасан байна.

Их Монгол Засахуй Ухаан намаас 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн хүсэлтдээ тус намыг “818 гишүүнтэй” гэж гишүүдийн бүртгэл хавсарган шүүхэд ирүүлснийг шалгаж үзэхэд, эцэг /эх/-ийн нэр зөрсөн-31, өөрийн нэр зөрүүтэй-8, регистрийн дугаар зөрүүтэй-181, жагсаалтад бүртгэгдсэн бүх мэдээлэл зөрүүтэй-15, ургийн овог зөрүүтэй-184, хаягийн мэдээлэл зөрүүтэй-205, огт мэдээлэл бүртгэгдээгүй-1, нас барсан-1 гэсэн зөрчил илэрсэн. Түүнчлэн, дэмжигч 818 гишүүдийн бүртгэлд 10 гишүүнийг давхардуулан бүртгэжээ.

Иймээс нам нь 801-ээс доошгүй гишүүнтэй байх хуулийн шаардлагыг хангахгүй байна.

Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Намыг үүсгэн байгуулах хурлын бэлтгэлийг урьдчилан хангах ба зохион байгуулж явуулах газар, хугацааг 2 сарын өмнө төлөөлөгчдөд мэдэгдсэн байна” гэсэн хуулийн шаардлагыг хангаагүй, үүсгэн байгуулагчдын хурлын товыг төлөөлөгчдөд хуульд заасан хугацаанд мэдэгдээгүй байна.

Тухайлбал, Их Монгол Засахуй Ухаан нам үүсгэн байгуулах хуралдааны товыг мэдэгдсэн тухай “Өдрийн сонин”-ы хуулбарыг хавсаргасан боловч нотлох баримтын шаардлага хангаагүй, нөгөө талаар “Өдрийн сонин”-ы эх хувьд, 2022 оны 11 дүгээр сарын 21-ний №220 дугаарт “2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр нам үүсгэн байгуулах анхдугаар хурал болно” гэсэн зарыг түгээснээс үзэхэд нам үүсгэн байгуулах хурал болсны дараа сонинд зарлуулсан, утга агуулгын илэрхий зөрчилтэй байна.

Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Намыг үүсгэн байгуулах хуралд орон нутгаас төлөөлөх төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулна” гэж заасан, Их Монгол Засахуй Ухаан намыг үүсгэн байгуулах хуралд орон нутгаас төлөөлөгч оролцуулсан нь тодорхойгүй, холбогдох баримтыг ирүүлээгүй байна.

Дээрх үндэслэлүүдээр, Их Монгол Засахуй Ухаан намын хүсэлтийг хангахаас татгалзах нь зүйтэй гэж Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасныг баримтлан Их Монгол Засахуй Ухаан намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсугай.

2.Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ